



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/265

Арвайхээр

Д.Баянжаргалд буцалтгүй тусламж олгох
тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох” 7 дугаар тогтоолоор батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь;

1.Аймгийн Хөгжимт драмын театрт гоцлол дуучнаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгох болсон тул Даваадорж овогтой Баянжаргалд 17.300.115 (арван долоон сая гурван зуун мянга нэг зуун арван тав) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2.Дээрх буцалтгүй тусламжийн 17.300.115 (арван долоон сая гурван зуун мянга нэг зуун арван тав) төгрөгийг орон нутгийн төсвийн тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100589